



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/439

Улаанбаатар хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээ хүчингүй болгох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Захиргааны Ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.1, 49 дүгээр зүйлийн 49.3, Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.1, 35.3.3, 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6, Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг Тэц-4 станцын урд үйлдвэрлэлийн зориулалттай 1360 м2 газар эзэмшүүлсэн тус Дүүргийн Засаг даргын 2015 оны А/710 дугаар захирамжийн иргэн Бат-Өлзийгийн Баярсайхан (ХГ67051776)-д холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

2.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дүүргийн Газар зохион байгуулалтын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхтөр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЪЯАБААТАР